



**ДОРНОГОВЬ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 56

Дорноговь аймаг, Сайншанд сум

**“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг
хэрэгжүүлэх аймгийн зорилтод
хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 онь. “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 58 дугаар зарлиг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/06 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар зорилтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх аймгийн зорилтот хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.


2. Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, аймгийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулан, хэрэгжилтийн тайланг бүтэн жилээр гарган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Батжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, хөдөө аж ахуйн бодлогын хорооны ахлагч (П.Бямбанаранжав), аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Батсугир) нарт даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 22 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.


ДАРГА

Б.ТАНЗОРИГ



443020100

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны
өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
“ТЭРБУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЙМГИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Хөрс хамгаалах тухай хууль, Газрын тухай хуульд ногоон байгууламж, ойн санг нөхөн сэргээх, хамгаалах эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон байдаг.

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогын баримт бичиг, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 58 дугаар зарлиг, Ногоон хөгжлийн бодлого, Төрөөс ойн талаар баримтлах бодлого, Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн төлөө хамтдаа-2” 2020-2024 оны хөтөлбөрийн Ногоон хөгжлийн бодлогын зорилтуудын хэрэгжилтийг хангахад энэхүү хөтөлбөр үндэслэгдсэн болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

2.1.Хөтөлбөрийн зорилго: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах, төв суурин газрын тохижилтыг сайжруулах, хүн, байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийн цэвэр орчинд амьдрах орчныг бүрдүүлэх ажлыг аймаг, сум, баг, орон нутгийн онцлогт нийцүүлэн төлөвлөн хэрэгжүүлж, аймгийн хэмжээнд “20 сая мод” тарьж ургуулна.

2.2.Хөтөлбөрийн зорилт:


2.2.1.Төв суурин газрын тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах;

2.2.2.Орон нутгийн ойн ангиуд, нөхөрлөлүүдийг түшиглэн шинээр мод үржүүлгийн газар байгуулах, өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх;

2.2.3.Ойг нөхөн сэргээх иргэд, олон нийтийн санал санаачилга, оролцоог нэмэгдүүлж, ногоон төгөл байгуулахад дэмжлэг үзүүлэх;

2.2.4.Ногоон хөгжлийн түншлэлийг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх замаар ногоон эдийн засгийн хөгжил, өсөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

2.2.5.Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон мэргэжлийн байгууллагуудтай хамтарч цөлжилтөд өртөж доройтсон газрын судалгааг хийлгэж, судалгаанд үндэслэн ойжуулалтын ажлыг гүйцэтгэх;



ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1.“Төв суурин газрын тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах” зорилтын хүрээнд:

3.1.1.Хөтөлбөр хэрэгжих хугацаанд цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, ойн зурвас байгуулах талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах;

3.1.2.Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шинээр цэцэрлэгт хүрээлэн, төгөл байгуулах, цэцэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.3.Цэцэрлэгт хүрээлэн, нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжид дуслын усалгааны системийг нэвтрүүлж, усалгаа арчилгааг байгууллага, аж ахуй нэгжид хариуцуулах;

3.1.4.Төв, суурин газрын нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг мал сүйтгэх явдлыг зогсоож, төв, суурин газарт мал маллахыг хориглох;

3.1.5.Газрын тухай хуульд заасан эзэмшил газрын 10 хувийг ногоон байгууламжтай байлгах заалтыг хэрэгжилтийг хангах, шинээр баригдсан барилга байгууламжийг ногоон байгууламжийн хамт хүлээн авах;

3.1.6.Байгаль, түүх соёлын дурсгалт газруудыг иргэд, олон нийтийн оролцоотой тохижуулж, ногоон байгууламж бий болгох;

3.1.7.Иргэдэд мод тарих аргачлал, модны тайралт хэлбэржүүлэлтийн талаар сургалтыг тогтмол зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэх;

3.1.8.Жил бүр мод тарих, “Эко өрх, байгууллага” шалгаруулах аяныг зохион байгуулж байгууллага, аж ахуй нэгж, айл өрхүүдийг Ногоон төгөл байгуулах, мод, бут, сөөг тарихад дэмжлэг үзүүлж тарьц суулгачын худалдааг зохион байгуулах;

3.1.9.Ногоон байгууламж, зүлэгжүүлэлтийн ажлыг өөрсдийн санал санаачилгаар хийсэн, аж ахуй нэгж, иргэдийг шалгаруулж урамшуулах;

3.1.10.Сайншанд, Замын-Үүд сумын цэвэрлэх байгууламжаас гарсан саарал усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглах;

3.1.11. Экологийн боловсрол олгох, хандлагаа өөрчлөх зөв дадлыг бий болгох сургалт, нөлөөллийн ажлыг боловсролын бүх шатанд хэрэгжүүлэх;

3.2. “Орон нутгийн ойн ангиуд, нөхөрлөлүүдийг түшиглэн сумдад мод үржүүлгийн газар байгуулах, өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд:

3.2.1. Сум дундын ойн ангийг нэмэгдүүлж үйл ажиллагааг тогтворжуулах, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэн чадавхжуулж, шаардлагатай тоног төхөөрөмж багаж хэрэгслээр хангах;

3.2.2. Шинээр мод үржүүлгийн газар байгуулах, мод үржүүлгийн газруудыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Мод үржүүлгийн газрыг түшиглэсэн сургалтыг зохион байгуулах;

3.2.4. Говийн ховор ургамлыг үржүүлэх;

3.3. “Ойг нөхөн сэргээх иргэд, олон нийтийн санал санаачилга, оролцоог нэмэгдүүлж, ногоон төгөл байгуулахад дэмжлэг үзүүлэх” зорилтын хүрээнд:

3.3.1. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах;

3.3.2. Ойг хортон шавжаас хамгаалах тархалтын судалгааг явуулж түүнтэй тэмцэх ажлыг зохион байгуулах;

3.3.3. Гадаад, дотоодын байгууллагатай хамтран ойжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх, ойн зурвас байгуулах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.3.4. Газрын доройтол, цөлжилтийг сааруулахад чиглэсэн ойн зурвас байгуулах ажлыг эрчимжүүлэх;

3.3.5. Ойн нөөцийн хомстлоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох хяналт шалгалтыг зохион байгуулах;

3.3.6. Модны хэрэглээг хязгаарлах, мод модон материалыг орлох үйлдвэрлэлийг дэмжих;

3.3.7. Үүлэнд зориудаар нөлөөлөх ажлыг зохион байгуулж хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;

3.4. Ногоон хөгжлийн түншлэлийг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх замаар ногоон эдийн засгийн хөгжил, өсөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд:

3.4.1. Ногоон эдийн засгийн хөгжлийн талаар улсын болон бүс нутгийн арга хэмжээнд аж ахуйн нэгж байгууллага, нөхөрлөл, төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулан хамтын ажиллагааг өргөжүүлэх;


3.4.2. Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ногоон ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэсэн жимс, жимсгэний мод төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3.4.3. Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлж хөв цөөрөм байгуулах, байгаль орчинд ээлтэй усалгааны хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.4.4.Байгаль орчны дүйцүүлэн хамгаалах үүргийг ойн санг нэмэгдүүлэхэд чиглүүлж “Нэг тонн баялаг-Нэг мод” арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.4.5.Эко өрх, эко байгууллагыг шалгаруулж урамшуулах;

3.4.6.Нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийн усалгаа, мод үржүүлгийн газрын усалгааны зардлыг хөнгөлөх, чөлөөлөх бодлогыг хэрэгжүүлэх;



ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ХУГАЦАА

4.1.Хөтөлбөрийг 2021-2030 онд хэрэгжүүлнэ.

1-р үе шат: 2021-2025 он

2-р үе шат: 2025-2030 он

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ

5.1. Удирдлага, зохион байгуулалт:

5.1.1.Хөтөлбөрийн аймгийн хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих эрх, үүргийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар хэрэгжүүлэх бөгөөд сумын түвшинд сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг хариуцна.

5.1.2.Аймгийн ажлын хэсгийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга ахалж, шуурхай удирдлага, хяналтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст төвлөрүүлэн, ажлын хэсэгт Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, “Тохижилт-Сайншанд” хот тохижилтын газар болон ойн анги, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөл оролцоно.


5.1.3.Ажлын хэсгийн үйл ажиллагааны чиглэл

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж үнэлгээ өгөх, хөтөлбөрт өөрчлөлт оруулах саналыг холбогдох газарт гаргаж, шийдвэрлүүлэх;
- Сумдын ажлын хэсгийг арга зүйн удирдлагаар хангах;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах.

5.1.4.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд уул уурхай, төмөр зам, зэвсэгт хүчний анги салбар, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, орон нутгийн иргэдийн үүсгэл санаачилга, идэвх оролцоог дэмжиж, өргөнөөр татан оролцуулна.

5.2. Санхүүжилт

- 5.2.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө;
- 5.2.2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал;
- 5.2.3. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө;
- 5.2.4. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл тусламж;
- 5.2.5. Бусад эх үүсвэр;



ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин	Он /модны тоо/									
					2022	2023	2024	2025	2026	2027	2028	2029	2030	
1."Төв суурин газрын тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах" зорилтын хүрээнд														
1	Ногоон байгууламж хэмжээ	Тоо	235422	20235422 ширхэг модоор өссөн байна.	400000	1000000	1400000	1800000	2000000	2600000	3400000	3600000	3800000	
2	Мод тарьж ургуулсан	Өрх	1933	13683	300	450	600	700	900	1500	1800	2500	3000	
	ААНБ	Тоо	334	1074	20	30	40	60	90	100	150	210	250	
2."Орон нутгийн ойн ангиуд, нөхөрлөлүүдийг түшиглэн сумдад мод үржүүлгийн газар байгуулах, өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд:														
1	Сум дундын ойн анги	Тоо	1	2	1	-	-	-	-	-	-	-	-	
2	Шинээр байгуулсан мод үржүүлгийн талбай	Тоо	3	9	2	1	1	1	1	-	-	-	-	
3."Ойг нөхөн сэргээх иргэд, олон нийтийн санал санаачилга, оролцоог нэмэгдүүлж, ногоон төгөл байгуулахад дэмжлэг үзүүлэх" зорилтын хүрээнд:														
1	Ойн сангийн талбай хэмжээ	Га	116893	116902 га -аар нэмэгдүүлнэ.	1	1	1	1	1	1	1	1	1	
4.Ногоон хөгжлийн түншлэлийг хэрэгжүүлэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх замаар ногоон эдийн засгийн хөгжил, өсөлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд:														
1	"Эко өрх", "Эко байгууллага"-аар шалгарсан	Өрх	Тоо	1350	150	150	150	150	150	150	150	150	150	
		ААНБ	Тоо	90	10	10	10	10	10	10	10	10	10	
2	Ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтын хүний нөөцийг нэмэгдүүлнэ.	Иргэн	Тоо	1340	80	100	120	140	160	180	200	220	240	
5. "Тэр бум" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв														
1	Орон нутгийн төсөв	Сая.төг	40.0	13304.0	700.0	1155.5	1275.5	1395.5	1515.5	1635.5	1755.5	1875.5	1995.5	

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

7.1. Төв, суурин газрын тохижилт, цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх, ойжуулалт, ойн зурвас байгуулах, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагаанаас улмаас эрчимтэй явагдаж байгаа цөлжилтийг сааруулах зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд 1 удаа аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний агентлаг, сумдаас гарган, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс ирүүлж, тайланг нэгтгэнэ. Нэгтгэсэн тайланд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

8.2. Хэрэгжилтийн хугацаа дуусахад аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эцсийн үр дүн, үр нөлөөг аймгийн Засаг дарга, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.